

НҮҮДЛИЙН СОЁЛ ИРГЭНШЛИЙГ СУДЛАХ ОЛОН УЛСЫН ХҮРЭЭЛЭН

**СЭЛЭНГЭ, ТӨВ, АРХАНГАЙ АЙМГИЙН ЗАРИМ
СУМДАД ХИЙСЭН ХЭЭРИЙН ХАЙГУУЛ
СУДАЛГААНЫ АЖЛЫН ТОВЧ ТАЙЛАН**

Тайлан боловсруулсан:

Профессор А.Очир

Магистр Г.Мандахбаяр

Улаанбаатар хот 2019

Төв, Сэлэнгэ аймагт хийсэн хайгуул судалгаа:

Нүүдлийн соёл иргэншлийг судлах олон улсын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан А.Очир болон тус хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан Г.Мандахбаяр, жолооч /8989 УБК Ланд-80 маркийн машин/ С.Гүрсэд нар 2019 оны 6-р сарын 23-аас 26-н хүртэл 4 хоногийн хугацаанд Төв аймгийн Угтаалцайдам, Цээл, болон Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутагт хээрийн хайгуул судалгааны ажлыг хийлээ. Хээрийн судалгааны ажлын зорилго нь Угтаалцайдам буюу Жаргалант сумын нутагт 1910-аад онд Финийн Монголч эрдэмтэн Рамстетийн олж үзсэнээс хойш огт олдоогүй өдгөө хүрсэн Сүүжийн бичээсийг хайх, Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутаг Цант хэмээх газарт буй эртний хотын агаарын зураг /дронн/ авах, тодорхойлолт хийх зэрэг байв.

Угтаал буюу Жаргалант сумын нутагт Рамстет үзсэн гэх эртний хөшөө чулуу байгаа, эсэхийг шалгах, хэрэв байвал илрүүлж, судалгааны эргэлтэд оруулахаар хайгуулыг ажлыг хийсэн. Рамстедийн тэмдэглэлд гардаг, түүний явж өнгөрсөн Сүүж уул, Долоон худаг нь одоогийн Угтаал, Цээл сумын нутаг бөгөөд бид Сүүж уул, Долоон худаг орчимд 2 хоногийн хугацаанд хайгуул хийсэн боловч Рамстедийн үзсэн гэх бичигт хөшөөг олж чадсангүй.

Цантын дэрсний балгас

Харин судалгааны хэсэгт багтсан Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутагт буй Цантын дэрсний балгасны ерөнхий зохион байгуулалтыг судлахаар хоёр хоногийн хугацаанд ажиллаж, агаарын болон фото зураг авч, дурсгалын байршлыг тогтоон, дурсгалын он цаг, зориулалтыг тогтоож болохуйц зарим түүвэр олдворыг илрүүллээ.

Цантын дэрсний балгасыг профессор А.Очир болон ОХУ-ын эрдэм анх 199.... онд үзэж, уг дурсгалыг XIV зууны үед хамаарч болохыг зарим түүвэр олдворт тулгуурлан тогтоожээ. Хэрмийн дотор талд дугуй хэлбэртэй хоёр ширхэг чулуун тээрэм байх бөгөөд дэрс боловсруулж цаас хийдэг агсныг тогтоосон байна. Ингэснээрээ XIV зуунд монголчууд цаасны үйлдвэртэй байсныг харуулж байгаагаараа ихээхэн ач холбогдолтой, сонирхолтой дурсгал болох юм. Уг чулуун тээрмийн тухай хойно дэлгэрэнгүй тайлбарлана.

Уг дурсгал нь Сэлэнгэ аймгийн Орхон сумын нутаг, Орхон сумын төвөөс урагш 2,5 км орчим, Орхон голын зүүн хөвөөнд, сумын төвийн засмал замаас баруун тийш 300 орчим зайтай. Дурсгалын байрлал нь.

Зүүн уртрагийн $49^{\circ}7'30.00''$

Хойт өргөрөгийн $105^{\circ}22'58.29''$ солбицолд, далайн түвшнээс дээш 720 метрийн өндөрт.

Цантын дэрсний балгас нь 470×487 м хэмжээтэй, тэгш дөрвөлжин зохиомжтой шороон хэрэм бүхүй хэрмийн гадуураа шуудуутай юм. Хэрэм нь зарим хэсэгтээ ихэд баларсан, ялангуяа голын эрэгт тулсан хэсгээрээ мэдэгдэхгүй болсон байна. Хэрэм нь тэг дундуураа хөндлөн гудамжтай байсан нь тодорхой мэдэгдэнэ. Хэрэм дотор, зүүн урд өнцөгт нь давхар шороон байгууламжтай байсны үлдэл тодорхой үлдсэн байна. Хэрэм дотор барилга байсан нь мэдэгдэх боловч зохион байгуулалт нь тодорхой сайн мэдэгдэхгүй байна. Хэрмийн хаалга нь өмнөд талдаа, одоо мэдэгдэж байгаа хаалгын урт нь 25 метр орчим. Хэрэм дотроо барилгын туурь байхаас гадна хэрмийн гадна, өмнө талд олон жижгэвтэр барилгын үлдэгдэл мэдэгдэж байна.

Хэрмийн дөрвөн өнцгийн солбицол нь:

Баруун хойт: $N 49^{\circ} 7'37.26''$, $E 105^{\circ}22'45.29''$,

Баруун урд: $N 49^{\circ} 7'22.18''$, $E 105^{\circ}22'46.43''$,

Зүүн хойт: $N 49^{\circ} 7'38.39''$, $E 105^{\circ}23'9.49''$,

Зүүн урд: $N 49^{\circ} 7'23.37''$, $E 105^{\circ}23'11.56''$ болно.



Цантын дэрсний балгасны агаарын зураг /хойт талаас/

Цантын дэрсний балгасыг судлаачид XIY зууны үеийн дурсгал гэж үздэг. Хэрэмд буй дугуй тойрог бүхүй хоёр ширхэг чулуун тээрэм нь судлаачдын сонирхлыг ихэд татсаар ирсэн бөгөөд А.Очир тэргүүтэй дотоод, гадаадын эрдэмтэд үзэж судлаад, энэ нь цаас боловсруулах тээрэм мөн болхыг тогтоосон нь монголчуудын үйлдвэрлэлийн түүхэнд гаргасан томоохон ололт, амжилт мөн болохыг тогтоосон нь шинжлэх ухааны өндөр ач холбогдолтой юм. Чулуун тээрмийг өмнөд тал бүхүйг нь Тээрэм -1, түүний хойно оршихийг нь Тээрэм-2 гэж дугаарлан тодорхойлолт үйлдэв.

Тээрэм -1: Харьцангуй сайн хадгалагдсан. Тойрог нь анхны байрлалаараа бүтэн хадгалагдан үлдсэн. Тойргийн голч, чулууны гадна талдаа 7 м, дотор талдаа 590 см. Чулуун тээрмийн ховил хоорондын зай 40 см, ховилын өргөн 13 см. Нийт 14 ширхэг боржин чулууг ховил гаргаж, дугуйруулан тавьсан.



Чулуун тээрэм – 1. Агаарын зураг /дээрээс/



Чулуун тээрэм – 1. Агаарын зураг /баруун хойноос/



Чулуун тээрэм – 1. /хажуугаас/

Тээрэм -2: Чулуун тээрэм -1 –ээс хойш 100 орчим метр зайтай. Хадгалалт муу, анхны байрлалаас нь хөдөлгөж, эмх замбараагүй болгосон. Тээрмийн чулууны зузаан 45 см, өндөр нь 50 см, ховил доторх зай 35 см, ирмэгийн зузаан 18 см. 100-150 см орчим урттай 13 ширхэг чулуугаар уг тээрмийг үйлдсэн байна. Тойргийн голч ойролцоогоор 620 см.



Тээрэм -2. /Агаарын болон фото зураг/



Чулуун тээрмийн деталь хэсгүүд

Хэрэмд дээрх 2 ширхэг цаас боловсруулах чулуун тээрэм байхаас гадна тариа цайруулах, боловсруулах, гурил хийх чулуун тээрмийн үлдэгдлүүд маш олон тоотой олдож байна. Тэдгээр чулуун тээрэм нь дугуй хэлбэртэй, тойргийн голч нь 80-100 орчим см, голдоо 4x4 см, гүн нь 7 хүртэлх см дөрвөлжин нүхтэй, Эдгээрийн зарим нь хагарсан

боловч нэлээдгүй хэд нь бүтэн үлдсэн төдийгүй, царай цайруулж гурил хийж байсан эргэлтийн ором нь чулуун тээрмийн гадаргуу дээр үлдэж хоцорчээ.





Тээрмийн чулуудын заримаас



Түүвэр олдвор




Түүвэр олдвор



Чулуун уур (Түүвэр олдвор)

Төв аймгийн Баяндэлгэр сумын нутаг дахь дөрвөлжин булш

2019 онд Төв аймгийн Баяндэлгэр сумын нутагт хоорондоо 10 км орчим зайтай, хоёр бүлэг дөрвөлжин булш байхыг үзэж танилцав. Эхнийх нь Нүдэн булаг хэмээх газар орших булшууд бөгөөд байрлал нь хойт өргөрөгийн $47^{\circ}47'39.10''$, зүүн уртрагийн $108^{\circ}02'01.30''$, далайн түвшнээс дээш 1558 метр өндөрт оршино. Ойролцоо байх давхраатан тогтсон хадыг хуулж дөрвөлжин булшийг үйлдсэн болох нь мэдэгдэж байна.



Төв аймгийн Баяндэлгэр сумын Нүдэн булгийн дөрвөлжин булшны агаарын зураг



Төв аймгийн Баяндэлгэр сумын Нүдэн булгийн дөрвөлжин булины агаарын зураг



Хашлага нь улаан зостой дөрвөлжин були



Нүдэн булгийн дөрвөлжин булш



Нүдэн булгийн дөрвөлжин булшны хашлага чулуун дээрх буга



Судалгаа хийж буй байдал

Нүдэн булгийн дөрвөлжин булшууд нь зүүн талдаа хөшөө чулуудтай юм. Хүний дүрсийн тойм байдлаар дүрсэлсэн хөшөө чулууд хэд байна. Үүнд,

Хөшөө чулуу 1. Эгнээ бүхүй дөрвөлжин булшны зүүн талд булшнаас 770 см зайд хүний төрх оруулан үйлдсэн болхи хийцтэй хөшөө чулууг нүүрийг баруун тийш харуулан газарт босгожээ. Хөшөө чулууны хөрс газрын хөрснөөс 60 см, өргөн доогуураа 50 см, толгой өндөр 37 см, толгойн өргөн 39 см, чулууны зузаан 13 см. Хөшөө чулуунаас чанх урагш 10 орчим чулууг газар зоосон байна.



Нүдэн булгийн хөшөө чулуу 1

Хөшөө чулуу 2. Босоо чулуун хашлага \хашлагатаа улаан зостой\ бүхүй дөрвөлжин булшнаас зүүн тийш 80 градуст 8 метр орчим зайд дээд хэсэг нь хагарч унасан хөшөө чулууны хэсэгт байна. Нүүрийг баруун зүг хандуулан үйлдсэн, дээд хэсэг нь хугарч унасан, одоогийн байгаа өндөр нь 26 см, өргөн 38 см, зузаан 8 см. Хөшөө чулууний өмнөд талд чулуу байх ба хөшөө чулуунаас урагш 2 ш чулууг газарт зоосон байна.




Нүдэн булгийн хөшөө чулуу 2

Адуун чулууны дөрвөлжин булш

Мөн сумын нутаг Адуунчулуун хэмээх газар уулын энгэрт буй хэдэн бүлэг 200 булш юм. Байрлал нь хойт өргөрөгийн $47^{\circ}45'25.40''$, зүүн уртрагийн $108^{\circ}11'47.10''$, далайн түвшнээс дээш 1511 метр өндөрт оршино.

Тэдгээр булшийг уулын энгэр түшүүлэн үйлдсэн ба зохион байгуулалт нь ерөнхийдөө хойноос урагш чиглэсэн эгнээ \гудамж\ байдлаар хийсэн нь ажиглагдах бөгөөд зарим тохиолдолд нэг эгнээнд 6 хүртэлх дөрвөлжин булш байна. Ийм зохион байгуулалт нь дөрвөлжин булшны соёлд түгээмэл ажиглагддаг. Дээрх 2 бүлэг дөрвөлжин булшны зохион байгуулалтаас харахад, чулуун хөшөөг эгнээ булшны голлох нэг булшинд эсвэл булш тус бүрд ч тавьсан нь ажиглагдаж байна.



Адуун чулууны дөрвөлжин бушины агаарын зураг

Адуун чулууны хөшөө чулуу: Адуун чулууны дөрвөлжин булш нь уулын энгэрт хэсэг бүлгээр байрлах бөгөөд уулын оройд 4x3 м орчим хэмжээтэй дөрвөлжин булшны зүүн хойна 10 орчим метр зайд нүүрээр нь дөрвөлжин булшны буюу зүүн зүгт хандуулан босгосон хөшөө чулуу аж. Газрын уруу хазаасан байдалтай, нүүрэн талд хүний нүүрийн зарим эрхтнийг болхи байдлаар дүрсэлсэн байна. Хөшөө чулууны өндөр 70 см, мөрний өргөн 45 см, эрүү хүртэл 42 см, нүүрийн өргөн 42 см, чулууны зузаан 16 см.



Адуун чулууны хөшөө чулуу

Энд байх бүлэг дөрвөлжин булшны зүүн талд хөшөө чулууны хэд хэдэн хувилбар байх бөгөөд тэдгээрийг зургаар оруулав.